



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар

1212

Мандалговь

Цахим хуудас хөгжүүлэлтийн ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоол, Төрийн байгууллагуудын цахим хуудсанд тавигдах MNS 6285:2011 стандарт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбогдуулан цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх, хөгжүүлэлтийг хариуцан ажиллах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүдэд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, авилгаас урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, хүн ам зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар

4823100587

2. Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Хариуцсан ажил үүргийн хуваарийн дагуу цахим хуудсанд мэдээллийг тогтмол оруулж, мэдээллийн чанар, хугацаанд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Н.Түвшинжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар сарын 11 ны өдрийн 44 дугаар захирамжийн хавсралт



ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН  
АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

№	Нэр	Чиг үүрэг
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангах
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Цахим хуудасны хэвийн үйл ажиллагаа, хөгжүүлэлт
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн мэргэжилтэн	Ил тод байдлын үзүүлэлт, цаг үеийн мэдээ мэдээлэл
3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, авилгаас урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн	Хууль эрх зүйн салбар, бодлогын үйл ажиллагааны мэдээлэл
4	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, хүн ам зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн	Нийгмийн хүрээний салбар, бодлогын үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл
5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн ахлах мэргэжилтэн	Төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээ, мэдээлэл
6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэр, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн	Цахим хуудсуудын мэдээ, мэдээлэлд хууль, тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж өгөх
7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн	Хөгжлийн бодлогын хэлтсийн хүрээний мэдээ, мэдээлэл
8	Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар	Тухайн сумын цахим хуудасны мэдээ, мэдээлэл